



### **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/125/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	16
3.4 Материаллаг байдал .....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	19
3.8 Аудитын гол асуудал .....	20
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	20
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	20
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт .....	21
4.1 Залруулсан алдаа.....	21
4.2 Төлбөрийн акт.....	21
Байхгүй .....	21
4.3 Албан шаардлага .....	21
4.4 Зөвлөмж .....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	22

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 4 ДҮГЭЭР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Х.ХАЙРАТ ТАНАА

2022.02.25 № 047  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *[Signature]* М.ХУАНГАН

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>103,793,158.90</u></b>	<b><u>102,986,963.90</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
31110	Төгрөг	-	-
31140	Касс арилжааны банк	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31213	Арилжааны банк дахь харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,046,653.00	1,164,458.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,046,653.00	1,164,458.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	101,746,505.90	101,822,505.90
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	101,746,505.90	101,822,505.90
35410	Бичиг хэргийн материал		
35420	Аж ахуйн материал	3,008,200.00	3,084,200.00
35470	Бусад хангамжийн материал	98,738,305.90	98,738,305.90
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,040,613,329.13</u></b>	<b><u>1,961,258,946.46</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,040,613,329.13	1,961,258,946.46
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,833,721,329.13	1,754,366,946.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,845,948,850.18	1,845,948,850.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	(256,635,056.41)	(332,896,225.93)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		24,750,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(3,712,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	261,664,641.47	230,108,628.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	(215,727,205.42)	(211,879,079.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	132,611,393.36	127,369,748.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	(99,126,247.01)	(97,087,565.94)
39209	Зам, гүүрийн байгууламж	-	-
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	-
39214	Бусад үндсэн хөрөнгө	61,644,200.00	61,644,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(27,425,166.12)	(33,516,666.43)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном	130,765,919.08	143,637,557.58

<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	206,892,000.00	206,892,000.00
39301	Програм хангамж	750,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(750,000.00)	(750,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	206,892,000.00	206,892,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,144,406,488.03</u></b>	<b><u>2,064,245,910.36</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>31,032,286.00</u></b>	<b><u>31,032,286.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	31,032,286.00	31,032,286.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	31,032,286.00	31,032,286.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	31,032,286.00	31,032,286.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,113,374,202.03</u></b>	<b><u>2,033,213,624.36</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,113,374,202.03	2,033,213,624.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	933,880,457.00	933,880,457.00
51101	Өмч: - төрийн	933,880,457.00	933,880,457.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(195,302,940.24)	(275,463,517.91)
51210	Өмнөх үеийн үр дүн	(218,570,835.69)	(195,302,940.24)
51220	Тайлант үеийн үр дүн	23,267,895.45	(80,160,577.67)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,374,796,685.27	1,374,796,685.27
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,144,406,488.03</u></b>	<b><u>2,064,245,910.36</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,207,303,998.08</b>	<b>2,201,832,970.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>38,552,934.35</b>	<b>629,617.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	38,552,934.35	629,617.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	38,552,934.35	629,617.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	38,552,934.35	629,617.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,168,751,063.73</b>	<b>2,201,203,353.50</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,959,260,314.73	1,979,573,638.50
131005	Хөрөнгийн санхүүжилт	48,205,814.73	11,821,638.50
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,911,054,500.00	1,967,752,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,684,249.00	11,664,915.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,684,249.00	11,664,915.00
131106	Төсвийн урамшуулал	-	-

<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	204,806,500.00	209,964,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	204,806,500.00	209,144,800.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	-	820,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,184,036,102.63</b>	<b>2,281,993,548.17</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,184,036,102.63</b>	<b>2,281,993,548.17</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,128,121,102.63	2,226,693,848.17
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,568,702,771.00	1,621,366,353.00
210101	Үндсэн цалин	1,403,540,251.00	1,513,172,353.00
210104	Урамшуулал	165,162,520.00	108,194,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	209,117,918.00	217,611,742.00
210201	Тэтгэврийн даатгал	132,564,218.00	152,966,942.00
210202	Тэтгэмжийн даатгал	30,319,800.00	16,161,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,329,000.00	12,929,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,082,300.00	3,232,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,822,600.00	32,322,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	205,406,500.00	207,644,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,483,800.00	4,431,900.00
210302	Түлш, халаалт	188,301,700.00	189,940,000.00
210303	Цэвэр, бохир ус	13,621,000.00	13,272,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	33,743,161.00	31,034,068.00
210401	Бичиг хэрэг	2,430,495.00	1,596,000.00
210402	Тээвэр, шатахуун	23,806,800.00	25,204,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,718,000.00	1,173,251.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,587,866.00	2,377,217.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	283,200.00	2,464,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	283,200.00	384,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,080,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	2,237,849.00
210604	Урсгал засвар	-	2,237,849.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,832,600.00	672,000.00
210702	Дотоод албан томилолт	2,832,600.00	672,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	373,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	373,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	108,034,952.63	143,289,436.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,286,236.00	48,594,415.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	89,748,716.63	94,695,021.17
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	55,915,000.00	55,299,700.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	31,266,050.00	52,554,400.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,266,050.00	52,554,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	24,648,950.00	2,745,300.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,648,950.00	2,745,300.00
213304	Хөрөнгийн	-	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-
220001	Барилга байгууламж	-	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>23,267,895.45</u></b>	<b><u>(80,160,577.67)</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
145003	Хөрөнгө оруулалтын олз	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
225002	Найдваргүй авлагын алдагдал	-	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>23,267,895.45</u></b>	<b><u>(80,160,577.67)</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	933,880,457.00	1,374,796,685.27	(195,302,940.24)	2,113,374,202.03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	933,880,457.00	1,374,796,685.27	(195,302,940.24)	2,113,374,202.03
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C07	Тайлант үеийн үр дүн				-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	933,880,457.00	1,374,796,685.27	(195,302,940.24)	2,113,374,202.03
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	933,880,457.00	1,374,796,685.27	(195,302,940.24)	2,113,374,202.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	933,880,457.00	1,374,796,685.27	(195,302,940.24)	2,113,374,202.03
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D08	Тайлант үеийн үр дүн			(80,160,577.67)	(80,160,577.67)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	933,880,457.00	1,374,796,685.27	(275,463,517.91)	2,033,213,624.36

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,120,545,249.00</b>	<b>2,188,561,715.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,120,545,249.00</b>	<b>2,188,561,715.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,911,054,500.00	1,967,752,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,911,054,500.00	1,967,752,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,684,249.00	11,664,915.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,684,249.00	11,664,915.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	204,806,500.00	209,144,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	204,806,500.00	209,144,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,100,616,749.00</b>	<b>2,185,862,715.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,100,616,749.00</b>	<b>2,185,862,715.00</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,048,605,849.00</b>	<b>2,130,563,015.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,571,130,800.00	1,619,919,700.00
210101	Үндсэн цалин	1,403,540,251.00	1,511,725,700.00
210104	Урамшуулал	167,590,549.00	108,194,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	208,052,600.00	218,176,200.00
210201	Тэтгэврийн даатгал	131,498,900.00	153,531,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	30,319,800.00	16,161,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,329,000.00	12,929,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,082,300.00	3,232,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,822,600.00	32,322,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	204,806,500.00	207,644,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,483,800.00	3,483,800.00
210302	Түлш, халаалт	187,101,700.00	189,940,000.00
210303	Цэвэр, бохир ус	14,221,000.00	14,221,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	34,817,949.00	32,094,615.00
210401	Бичиг хэрэг	2,077,300.00	1,512,215.00
210402	Тээвэр, шатахуун	23,806,800.00	25,204,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,718,000.00	2,123,700.00
210404	Ном, хэвлэл	1,359,600.00	519,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,656,249.00	2,384,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,532,100.00	2,246,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	283,200.00	284,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,248,900.00	1,962,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	1,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар		1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,832,600.00	672,000.00
210702	Дотоод албан томилолт	2,832,600.00	672,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	981,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		981,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	22,433,300.00	47,327,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		10,489,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,433,300.00	36,838,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>52,010,900.00</b>	<b>55,299,700.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	27,361,950.00	52,554,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,361,950.00	52,554,400.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,648,950.00	2,745,300.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,648,950.00	2,745,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>19,928,500.00</u></b>	<b><u>2,699,000.00</u></b>
4	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>19,929,400.00</b>	<b>2,699,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>19,929,400.00</b>	<b>2,699,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	19,929,400.00	2,699,000.00
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,929,400.00	2,699,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(19,929,400.00)</u></b>	<b><u>(2,699,000.00)</u></b>
14	<b>Бусад эх үүсвэр</b>	-	-
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх		
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	-	-
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	≡	≡
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(900.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	900.00	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,176,896,800.00</b>	<b>2,174,151,500.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,176,896,800.00</b>	<b>2,174,151,500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,122,565,300.00</b>	<b>2,121,597,100.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,619,919,700.00	1,619,919,700.00
210101	Үндсэн цалин	1,511,725,700.00	1,511,725,700.00
210104	Урамшуулал	108,194,000.00	108,194,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	218,176,200.00	218,176,200.00
210201	Тэтгэврийн даатгал	153,531,400.00	153,531,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	16,161,200.00	16,161,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,929,000.00	12,929,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,232,200.00	3,232,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,322,400.00	32,322,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	207,644,800.00	207,644,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,483,800.00	3,483,800.00
210302	Түлш, халаалт	189,940,000.00	189,940,000.00
210303	Цэвэр, бохир ус	14,221,000.00	14,221,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	32,824,500.00	31,969,200.00
210401	Бичиг хэрэг	686,800.00	686,800.00
210402	Тээвэр, шатахуун	26,060,000.00	25,204,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,123,700.00	2,123,700.00
210404	Ном, хэвлэл	1,569,800.00	1,569,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,384,200.00	2,384,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,246,800.00	2,246,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	284,500.00	284,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,962,300.00	1,962,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,500,000.00	1,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	784,900.00	672,000.00
210702	Дотоод албан томилолт	784,900.00	672,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	981,100.00	981,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	981,100.00	981,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	38,487,300.00	38,487,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,487,300.00	38,487,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	54,331,500.00	52,554,400.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	54,331,500.00	52,554,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,331,500.00	52,554,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,176,896,800.00</b>	<b>2,174,151,500.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,967,752,000.00</b>	<b>1,965,006,700.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,967,752,000.00	1,965,006,700.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	209,144,800.00	209,144,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	209,144,800.00	209,144,800.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	128	132
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	94	97
620003	Үйлчлэх ажилтан	33	34
620004	Гэрээт ажилтан		
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	-	-
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	-	-
630001	Төрийн өмчит ЕБС		
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>128.00</b>	<b>132.00</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	95	98
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	33	34

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,684,249.00</b>	<b>11,664,915.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,684,249.00</b>	<b>11,664,915.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,684,249.00	11,664,915.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	-
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	1,175,415.00
210401	Бичиг хэрэг		825,415.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		350,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,684,249.00	10,489,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,684,249.00	10,489,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,684,249.00</b>	<b>11,664,915.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,684,249.00	11,664,915.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,684,249.00	11,664,915.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн №11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл:

Өлгий сумын сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн зорилго: “Хүүхдийн хоцрогдол арилгах, тэдний хөгжил төлөвшил, сургалтад ахиц гаргах, багш ээлжит хичээлийн бэлтгэлийг өндөр түвшинд хангаж, мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломж бүрдүүлэх”

Энэхүү зорилгыг хангах чиглэлээр “суралцагчдыг сурлагаар хоцрох, сургууль завсардах эрсдэлээс сэргийлэх, элсэлтийн ерөнхий шалгалтад амжилттай бэлтгэхэд багш, сурагчдад дэмжлэг үзүүлэх, хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжихэд эцэг эх, асран хамгаалагч олон нийтийн оролцоо, түншлэлийг хөгжүүлэх, хос хэлээр сургалт явуулдаг бага ангийн суралцагсдыг монгол хэлний хичээлийн хөтөлбөр, сурах бичгээр хангах” гэсэн зорилтын дор ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус сургуульд дотоод аудитор ажилладаггүй, тайлант онд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгдэж, зөрчил дутагдал гараагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2184.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 21.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 13.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өлгий сумын сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 80.1 сая төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	2,046.7	1,164.5	(882.2)
Урьдчилгаа			-
Бараа материал	101,746.5	101,822.5	76.0
Үндсэн хөрөнгө	2,040,613.3	1,961,258.9	(79,354.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,144,406.5</b>	<b>2,064,245.9</b>	<b>(80,160.6)</b>
Өр төлбөр	31,032.3	31,032.3	-

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,113,374.2	2,033,213.6	(80,160.6)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,144,406.5</b>	<b>2,064,245.9</b>	<b>(80,160.6)</b>

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй, оны эхний 2.0 сая төгрөгийн цалингийн ашгийн татварыг барагдуулж, оны эцэст шинээр 1.2 сая төгрөгийн НДШ, цалингийн ашгийн авлагатай гарчээ. Урьдчилж гарсан зардал дансанд үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 101.8 сая төгрөг болж 0.08 сая төгрөгөөр буурсан. Аймгийн Боловсрол соёлын газраас 0.6 сая төгрөгийн ариутгалын бодис үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Тайлант онд 22.1 сая төгрөгийн бараа материал худалдан авсан, 0.6 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүй авч, 22.0 сая төгрөгийн материал зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1961.3 сая төгрөг болж 79.3 сая төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө, үндсэн хөрөнгийн элэгдэл, акталсан хөрөнгийн зөрүүгээр буурсан үзүүлэлттэй харагдаж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2.7 сая төгрөгийн, БШУЯ-наас үнэ төлбөргүй 12.6 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 124 тоот тогтоолоор Насан туршийн боловсролыг төвийн 8.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 6.1 сая төгрөгийн тавилга эд хогшлыг, нийт 14.5 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн өгсөн байна.

Өр төлбөр дансанд байгаа он дамжсан 31.0 сая төгрөгийн түлш халаалтын өглөг барагдаагүй байна. Сургууль нь түлш халаалтын зардлын 189.9 сая төгрөгийн батлагдсан төсвийг “Эрчим” ХХК-д бүрэн шилжүүлсэн бөгөөд тус компаниас ирүүлсэн жилийн эцсийн тооцооны үлдэгдлийн баталгаагаар оны эхний үлдэгдлийг оруулан тооцсон 67.1 сая төгрөгийн халаалтын зардлын өглөгтэй тооцоо гарсныг хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансанд өөрчлөлт гараагүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2201.8 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 5.4 сая төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хөрөнгө, бараа материалыг шилжүүлсэнтэй холбоотой буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 97.9 сая төгрөгөөр буюу 4.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, НДШ, тогтмол зардал, нормативт зардал, бараа үйлчилгээний зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт гараагүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны ээлжит II хуралдааны 16 дугаар тогтоолоор тус сургуулийн төсвийг нийтдээ 1864.9 сая төгрөгөөр баталсан байна. Нийт зарлагын 1655.7 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 209.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгажээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны Төсвийн сарын зохицуулсан хуваарь батлах тухай А/1093 тоот захирамжаар тус сургуулийн батлагдсан төсвийг 2176.9 сая төгрөг болгон өөрчилсөн байна.

Энэ нь анх батлагдсан төсвөөс үдийн цайны зардлаас 28.5 сая төгрөгөөр бууруулж, цалин, үр дүнгийн урамшууллын зардлыг 252.0 сая, НДШ-ийн зардлыг 33.5 сая, бага тээвэр шатахуун 25.0 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 30.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, батлагдсан төсвийг нийт дүнгээр 312.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Энэ нь анх баталсан төсөвт цалин, урамшууллын зардлыг 252.0 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийг 33.5 сая төгрөгөөр дутуу суулгасантай холбоотой байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2176.9 сая төгрөгийн төсөв баталснаас 1967.8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 209.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр төсвөөс 1967.8 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 209.1 сая төгрөг, нийт 2176.9 сая төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2174.2 сая төгрөгийг зарцуулж 2.7 сая төгрөгийг хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнд: томилолтоос зардлыг 0.1 сая, тээвэр шатахуунаас 0.8 сая, үдийн цайны зардлаас 1.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Тээвэр шатахуун, хичээл практикийн зардалд хуваарилагдаагүй зардлаас аймгийн Боловсролын газарт 54.2 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр арга хэмжээ, батлагдсан төсөв гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

№	Хөтөлбөр	Арга хэмжээ	Нэршил	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	70802	70602	Ерөнхий боловсрол			
2		80109	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	207,644.8	207,644.8	-
3		81801	үдийн цай хөтөлбөр	54,331.5	52,554.4	1,777.1
5		81834	Боловсролын стандарт, сургалты	1,342,396.3	1,342,283.4	112.9
6		81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	571,024.2	570,168.9	855.3
<b>Нийт дүн</b>				<b>2,176,896.8</b>	<b>2,174,151.5</b>	<b>2745.3</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Боловсролын газраас ариутгалын зардалд 0.4 сая, тэтгэлэгт хөтөлбөрийн зардалд 10.5 сая, үнэлгээ тогтоох шалгалтын зардалд 0.8 сая нийтдээ 11.7 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэн зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийг 1 хөтөлбөр, 1 төсөл арга хэмжээний зардалд 10.5 сая төгрөгийг бараа үйлчилгээний, 1.2 сая төгрөгийг хангамжийн зардлуудад зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Өлгий сумын сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд “Эрчим” ХХК-ны жилийн эцсийн тооцооны үлдэгдлийн баталгаагаар гарсан 67.1 сая төгрөгийн халаалтын зардлын өглөгтэй холбоотой тооцоог хүлээн зөвшөөрөөгүй асуудлыг санхүүгийн тайланд тодруулж толилуулаагүй байна.

Тус сургууль нь “Эрчим” ХХК-тай 2021 онд халаалтаар хангах гэрээг шинэчлэн байгуулаагүй бөгөөд 2020 онд 8 сараар сард 28.3 сая төгрөгийн, жилд 226.3 сая төгрөгийн халаалт авахаар гэрээ байгуулсан байна.

Сургууль нь 2021 онд түлш халаалтын зардалд батлагдсан 189.9 сая төгрөгийн төсвийг бүрэн шилжүүлсэн бөгөөд жилийн эцсийн тооцооны үлдэгдлийн баталгаагаар он дамжсан 31.0 сая төгрөгийн үлдэгдэл, тайлант оны тооцооны зөрүү 36.1 сая төгрөгийн нийт 67.1 сая төгрөгийн өглөгийг хүлээн зөвшөөрч баталгаажуулаагүй байна.

Сургуулийн зүгээс халаалтын зардалд батлагдсан төсвийг бүрэн шилжүүлсэн тул тооцоо нийлсэн актыг хүлээн зөвшөөрч гарын үсэг зуураагүй, санхүүгийн тайланд тусгаагүй гэсэн тайлбарыг өгсөн байна.

Өлгий сумын сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардалд 1619.9 сая төгрөг, НДШ-ийн зардалд 218.2 сая төгрөг, тогтмол зардалд 207.6 сая төгрөг, боловсролын хуваарилагдаагүй зардалд 54.2 сая төгрөг, үдийн цайны зардалд 52.6 сая төгрөг нийтдээ 2152.5 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэл нийт 2174.2 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлын дүн 2152.5 сая төгрөгийг хасахад 21.7 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 2.1 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба 2021 онд төсвөөс 2.7 сая төгрөгийн хэмнэж төвлөрүүлсэн тул Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдсан гэж үзлээ.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь 2021 онд нийт 2006.3 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2006.3 сая төгрөгийн 104 мэдээллийг хугацаандаа байршуулж, 13 мэдээллийн хугацаа хочроож мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 заалттай зөвлөмж өгөгдсөнийг биелүүлж ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарал татахуйц онц асуудал байхгүй, санхүүгийн тайлангийн аудитыг түүврийн аргаар эрсдэлд тооцож үзсэн тул төсвийн зарцуулалтыг бүрэн үзэх шаардлагатай байна.

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 46.7 сая төгрөгийн зөрчилд нэг зөвлөмж өгөгдлөө.

##### **4.1 Залруулсан алдаа**

Байхгүй

##### **4.2 Төлбөрийн акт**

Байхгүй

##### **4.3 Албан шаардлага**

Байхгүй

##### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Өлгий сумын сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь аймгийн төвийн байгууллагуудыг төвлөрсөн халаалтаар хангагч “Эрчим” ХХК-наас ирүүлсэн 2021 оны жилийн эцсийн тооцоо нийлсэн актаар он дамжсан 31.0 сая төгрөгийн үлдэгдэл, тайлант оны тооцооны зөрүү 36.1 сая төгрөгийн, нийт 67.1 сая төгрөгийн өглөгийг хүлээн зөвшөөрч баталгаажуулаагүй байгаа нь үндэслэлгүй байна.

Сургууль нь 2021 онд түлш халаалтын зардалд батлагдсан 189.9 сая төгрөгийн төсвийг бүрэн шилжүүлсэн боловч энэ нь халаалтын зардлыг төсөвт дутуу суулгасанаас үүссэн өглөг байна. Энэ нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, толилуулга зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 “Энэ хуулийн 5.1.2-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.3.2 “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 26 дугаар зүйлийн 26.1 “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн зарчим”, 5.1.4 “үнэн зөв байх”, 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.3 “бүх өр төлбөр”, 14.4.6 “бүх зардал”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалтуудыг баримталж тооцоогоор үүссэн өр төлбөрийг батагаажуулан санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж тайлагнах.

#### **2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал**

##### **2.1. Илрүүлэлт:**

Тайлант онд худалдан авсан үдийн цай 41.8 сая төгрөгийн, бусад зардал 4.6 сая төгрөгийн нийт 46.5 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

**2.2. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 14.4, 14.4.5, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудыг мөрдөж худалдан авсан бараа материал, зардлыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгаж, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өлгий сумын ЕБ-ын 4 дүгээр сургууль	2	113.5							2	113.5